



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Булган-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4 нэрийн, нийт 24,786,946.00 (хорин дөрвөн сая долоон зуун наян зургаан мянга есөн зуун дөчин зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Булган-АЗЗА" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга О.Мөнхсоёл, гүйцэтгэх захирал Б.Батсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

200700

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ний
өдрийн 384 дүгээр тогтоолын хавсралт

**"Булган-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас
хасах хөрөнгийн жагсаалт**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ , Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөг)
1	Вагончик	2006	ш	1	1,706,300.00	1,706,300.00
2	Багажны ком	2012	ш	1	3,284,000.00	3,284,000.00
3	Чиргүүл	2009	ш	1	8,273,215.00	8,273,215.00
4	Чирдэг грейдер	2009	ш	1	11,523,431.00	11,523,431.00
				4		24,786,946.00
	Нийт дүн			4 (дөрөв)		24,786,946.00 (хорин дөрвөн сая долоон зуун наян зургаан мянга есөн зуун дөчин зургаан)